



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/101

Хэрлэн сум

Дотоод аудитын хороо байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлдагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.12, 4.13, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дотоод аудитын үйл ажиллагаа өөрийн төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дотоод аудитын
хорооны дарга

Ц.Чогсомжав

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн
дарга

Ш.Цамбасүрэн

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор

Гишүүд:

С.Нямдавга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

С.Жав

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор

Ж.Ганбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Ц.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Хараат бус гишүүн:

Ц.Чинзориг

Аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн
Төлөөлөгч

Хурлын

2.

2.Дотоод аудитын хороо нь үйл ажилтагаандаа Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг даалгасугай.

3.Уг захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/231 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

